

“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО”-НЫ НЭГЭН
ҮГИЙН ТОВЧ УТГА

Г. Буянтогтох*

Монгол хэл, сэтгэлгээний түмэн нууцыг хадгалсан “Монголын нууц товчоо” зохиолын 166-р зүйлд “Аман ину эчигэ көү кэ’эжү аму. Абури ину ө’эрэ буй йу. Итэгэжүүй амуй та. Эсэ нэндэ’сү тан-а йау болкү”(Дашцэдэн. 2009. х - 102)¹ гэж гардаг. Энэ хэдэн үгийн нэндэ’сү гэдгээс бусдыг монгол бичиг мэддэг хүн ойлгож ухахад түвэггүй байгаа бөгөөд дурдсан үг 185-р зүйлд “... сөнид дүлилгээжү нэндэн бүчий-э кэ’эбэ”; 200-р зүйлд: “Боол нэжүн бодун эжэн-ийэн босожу нэндэжү барикү болба”; 244-р зүйлд: “Касар-и эсэ нэндэ’эсү мэдээ үгэй буй жа...” хэмээн гарч байна.

“Монголын нууц товчоо” судалж шинжилсэн, орчуулж хөрвүүлсэн зохиол бүтээлд энэхүү нэндэ хэмээх үгийг харилцан адилгүй ухаарч, өөр өөрөөр буулгасан байна. Үүнд,

1. “Аман дээрээ эцэг хөвүүн гэж байвч авир зан нь өөр биш үү? Итгэж байна уу, та ? Эс ухваас та нар юу болохыг мэдэж байна уу ?”(Алтан товч.1957.х-75)² гэжээ.

2. “Ам хэлэндээ аав хөвүүн гэдэг боловч авир санаа нь адбиш өөр биш үү? Түүнд итгэж байна уу? Хожидвол та нар юу болохоо мэдэж байна уу ?”(Дамдинсүрэн. 1947. х-118-119)³ гэжээ. 185; 200 дугаар зүйлд уул үгийг хөрвүүлэлгүй орхиод, 244-р зүйлд “эс болгоомжилбол” гэж буулгажээ.

3. “Аман дээрээ эцэг хөвүүн гэдэг боловч авир зан нь адбиш өөр болой. Бас итгэсээр байна уу? Эртхэн амжисж гар хөдлөхгүй бол хааш болохыг та мэдээрэй”(Мансан.1985. х-152)⁴ гэсэн байгаа бөгөөд 185-р зүйлд “амжин хүрч”, 200-р зүйлд “барих”, 244-р зүйлд “даруй тонилгохгүй бол” хэмээн буулгажээ.

4. “Эснэндвээс танаа юу болох?”(Чоймаа.2011. х-108)⁵ гэж хөрвүүлэлгүй аваад, “урьдчилбаас, өмнө нь эс завдваас; манж хэлэнд “нэндэ” нь урьдчилах гэсэн утгатай” хэмээн тайлбарлажээ. Ингээд, 185-р зүйлд “нэндэн”; 200-р зүйлд “нэндэж”; 244-р зүйлд “эс нэндвээс” хэмээн тус тус хөрвүүлэлгүй тэр чигээр нь хэрэглэжээ.

5. Франц хэлээр, ”Si vous ne prenez pas les devants, qu’advindra’t - il de vous ? -Хэрэв та урьтаж авахгүй бол танд юу тохиолдохыг мэдэхгүй”(Пеллио.1949.х - 85)⁶ гэж орчуулжээ.

6. Орос хэлээр, “Что с вами станется , если только вы не опередите его? -Түүнээс эс урьтвал

* Монгол Улсын Их Сургууль, Монгол Хэл Соёлын Сургууль

¹ Т.Дашцэдэн. “Монголын нууц товчоо” –ны галиг.УБ. 2009

² Лувсанданзан. “Алтан товч”.УБ. 1957

³ Ц. Дамдинсүрэн. ”Монголын нууц товчоо”.УБ. 1947

⁴ Мансан. “Шинээр орчуулж тайлбарласан “Монголын нууц товчоо”. 1985

⁵ Ш.Чоймаа. “Монголын нууц товчоо”. Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг”.УБ. 2011

⁶ Pelliot Paul. Histoire secreete des Mongols.Paris. 1949

та ер нь яах л бол доо?” (Козин.1941. х-127)⁷ гэх буюу внезапным налетом - гэнэт довтлон, не предупредишь - эс өрсөх, эс урьтах гэх мэтээр орчуулжээ.

Польш⁸ хэлээр дээрх үгийг урьтах өрсөх хэмээн орчуулж, казах⁹ хэлээр гэнэдүүлэх, өрсөх гэсэн утгатай үгээр хөрвүүлжээ. Ер нь, “Монголын нууц товчоонд” нэндээсү, нэндэн, нэндэжү, эс нэндээсү хэмээн дөрвөн удаа гарч байгаа энэхүү нэндэ язгууртай үйл үг чухам ямар утгатай үг вэ?

Энэ үгийн утгыг монгол хэлний тольд “НЭНДЭХ дэндэх, хэтрэх, хэтэрхийдэх”(Цэвэл. 1966. х-398)¹⁰; “НЭНДЭ гэнэтээр дайрах”(Сэцэнцогт.1988. х-533)¹¹ хэмээн тайлбарласан байгаа бөгөөд “Монголын нууц товчоо”-ны нэлээд хэдэн хөрвүүлэгт эс ухваас, хожидвол, эс болгоомжилбол, эртхэн амжиж гар хөдлөх, амжин хурч барих, даруй тонилгох гэж буулгасан нь оновчгүй болжээ.

Харин, урьдчилбаас, өмнө нь эс завдваас(Чоймаа.2011. х-108)¹² хэмээн тайлбарласан нь уул үгийн бодит утганд маш дөхөж очсоны дээр франц хэлээр урьтаж, орос хэлээр, эс урьтвал, гэнэт довтлон, эс өрсөх, эс урьтах, польш хэлээр урьтах өрсөх гэсэн утгатай үгээр орчуулж; казах хэлээр гэнэдүүлэх, өрсөх гэх мэтээр хөрвүүлсэн нь зөв байна. Иймд, “Монголын нууц товчоо”-ны дурдсан үгийг орчуулсан, хөрвүүлсэн байдлаар нь оновчтой, оновчгүй хэмээн хоёр ангилж болохоор байна.

Энэхүү **НЭН** язгуурт үйл үг өвөг алтай хэлний үг байгаад хожим монгол, манж, казах, тува зэрэг олон хэл өвөг хэлнээс салбарлан гарахад утга салаалан хувирч, тэдгээр хэл тус бүрт өвөрмөц байдалтай болсон нь мэдээж юм.

Монгол хэлний тухайд бол, “Монголын нууц товчоо” зохиох үед идэвхтэй байсан энэ үгийн утга яваандаа сулран гээгдэж, зөвхөн дэндэх, хэтрэх, нэн их болох гэсэн салаа утга нь үлдээд, тэр нь ч бас өнөө үед идэвхгүй болж, зөвхөн нэн, эн гэсэн хоёр баймж утгат бүтээврийн төдий болсон байна. Энэ хоёроос гадна гэнэдүүлэх, гэнэдэх, нэнжих гэх мэт үгэнд ч эртний нэн язгуурын утга үлдсэн байгаа бөгөөд монгол хэлний нэн, эн баймжит бүтээврийг казах хэлэнд ен, тува хэлэнд эн гэж хөрвүүлнэ. Үүнд, казахаар ен басында, тувагаар эн баштай гэдэг нь эн тэргүүнд гэсэн урьтах, тэргүүлэх, түрүүлэхийн утгатай үг болно.

Өгүүлэн буй **НЭН** язгуурт үгийн эртний утгыг өвөг хэлнээс өвлөн авсан чигээр өнөөг хүртэл сайн хадгалсан алтай хэл гэвэл манж хэл байна. Энэ хэлэнд нэндэ-урьт, өрс, нэндэмби-урьтана, өрсөнө, нэндэн-урьтал, нэндэн обұха-урьтал болгов гэх мэт үгс харилцааны хэрэглүүрийн хувьд идэвхтэй хэвээр байгаа нь дээр дурдсаны гэрч мөний зэрэгцээ “Монголын нууц товчоо”-ны нэндээсү, нэндэн, нэндэжү, эс нэндээсү хэмээх үгийн утгыг урьтваас, урьтан, урьтаж, эс урьтваас, өрсөөс, өрсөн, өрсөж, эс өрсөөс гэх мэтээр зөв ухан тайлж унших ухаарах түлхүүр болж байна.

Summary

The Etymology of the word “**NENDE-beat someone to it**” of the “Secret History of the Mongols” is such as following :1. Proto Altaic - nen > Manchu - nende; > Mongolian - nenji, gene > genede. 2. Proto Altaic - nen > Mongolian - nen, en.

⁷ С.А. Козин. Сокровенное сказание. Монгольская хроника 1240 г. М-Л. 1941

⁸ S. Kaluzynski. Tauna Historia Mongolow6 Warszawa. 1970

⁹ Казахстаны түүхийн талаархи монгол мэдээ баримт. I боть. Монголын нууц товчоо. Алматы. “Дайк-Пресс” 2006

¹⁰ Я. Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 1966

¹¹ Сэцэнцогт. Монгол үгсийн язгуурын толь. 1988

¹² Ш. Чоймаа. “Монголын нууц товчоо”. Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг”. УБ. 2011